



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 11 сарын 25 өдөр

Дугаар 307

Улаанбаатар хот

Г Нэр бүхий 3 үнэт цаасны компанийн үндсэн харилцагчдын дансыг шилжүүлэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 51 дүгээр тогтоолоор баталсан “Үнэт цаасны брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд авах арга хэмжээний тухай журам”-ын 3.4, 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон "Фронтиер YЦК" ХХК, "Лондон Азия Капитал Монголия YЦК" ХХК, "Зууны Гарц Секьюритис YЦК" ХХК-ийн нийт 164 үндсэн харилцагчдын дансыг "Би Ди Сек YЦК" ХК-д шилжүүлэхийг "YЦТХТ" ХХК /Ж.Байгалмаа/-д зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зохицуулалттай этгээдийн эрх хүлээн авагч /Н.Нямдаваа/, "YЦТХТ" ХХК /Ж.Байгалмаа/, "Монголын хөрөнгийн бирж" ХК /Х.Алтай/, "Би Ди Сек YЦК" ХК /Д.Даянбилгүүн/-д тус тус үүрэг болгосугай:

1/ Тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон нэр бүхий 3 компанийн харилцагчдын данс нээсэн болон үнэт цаасны арилжааны хэлцлийн анхан шатны баримтыг 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн дотор хүлээлцэх;

2/ Тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон нэр бүхий 3 компанийн харилцагчдыг нэмэлт төлбөргүйгээр дансаа нээлгэж, үнэт цаасны арилжаанд оролцох боломжоор хангах;

3/ Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 87 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 51 дүгээр тогтоолоор баталсан “Үнэт цаасны брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд авах арга хэмжээний тухай журам”-д заасан үүргээ чанд биелүүлж ажиллах.

3. Шилжүүлэн авсан харилцагчдадаа шаардлагатай мэдээллийг 2019 оны 4 дугээр улиралд багтаан хүргэж ажиллахыг "Би Ди Сек YЦК" ХК /Д.Даянбилгүүн/-д даалгасугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.



ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

F:\ajil 2019\Blank\Togtool.doc

000627